# ШИНЖЭЭЧ СОНГОХ ЗАРЛАЛ

1. Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар нь Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх зорилгоор шалгагдагч этгээдийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр оролцох хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул оролцох хүсэлтэй аудитын хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.

2. Санхүүгийн тайлангийн аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх аудитын хуулийн этгээд нь ажлын багцад заагдсан Төсвийн шууд захирагчид болон төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн бэлтгэсэн 2021 оны санхүүгийн тайланг УСНББОУС, СТОУС, НББОУС болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэл, тайлагналын холбогдох заавар, журамд нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ.

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9-д заасан цаглаварт хугацаанд багтаан төрийн аудитын байгууллагын хянан удирдах ажилтнуудаар хянуулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.

Аудитад шалгагдагч этгээдийн 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгууд, ерөнхий дэвтэр, журнал, анхан шатны баримт шаардлагатай бусад баримтуудыг хамруулна.

3. Мэдүүлгээ ирүүлж буй шинжээч /аудитын хуулийн этгээд/ нь дараах материалыг ирүүлнэ. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын тодорхойлолт /цахим/;
- Нийгмийн даатгалын тодорхойлолт; /цахим/
- ШШГЕГ-ын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- ММНБИ-ын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн адил төсөөтэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Үндсэн ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Үндсэн ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Санхүүгийн тайлан /сүүлийн 2 жилээр/

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 09:00 цагаас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 17:00 цагийн хооронд авч болох бөгөөд материалаа дор дурдсан хаягаар 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 18:00 цагийн дотор цаасаар болон цахим хэлбэрээр Uvurkhangai@audit.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХОЛБОО БАРИХ УТАС: 70323833,99328832, 70323108, 99017254